



## **“ХЭРЭГЛЭЭНИЙ МАТЕМАТИК 2017” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

**Хурлын зохион байгуулалт:** Хурал 2017 оны 11-р сарын 25-ны өдөр МУИС-ын Төв номын сангийн байрны ..... тоот өрөөнд 10-18 цагийн хооронд болно. Хурлыг нэгдсэн ба салбар хуралдаанаар зохион байгуулна.

**Зохион байгуулагч:** МУИС-ХШУИС- Хэрэглээний математикийн тэнхим

**Хурлын зорилго:** Хэрэглээний математикийн ухааны хөгжлийн чиг хандлага, онол практикийн асуудлууд, эдийн засаг, инженерчлэл, нийгэм, банк санхүү, даатгал, байгаль орчин, хөдөө аж ахуй, ус, цаг уур зэрэг бусад салбаруудад тулгарч байгаа болон тулгарч болох математик асуудлуудыг тодорхойлох, арга туршлагаа солилцох хамтран үр ашигтайгаар шийдвэрлэх, хамтран ажиллахад энэ хурлын ач холбогдол оршино.

**Хамрах хүрээ (хэлэлцэх асуудлын чиглэлүүд):**

- Тооцон бодох математик
- Дифференциал тэгшитгэл, тухайн уламжлалт дифференциал тэгшитгэл
- Оновчлол, оновчтой удирдлага
- Санхүүгийн математик, даатгалын математик, эрсдлийн шинжилгээ
- Цаг уур
- Ус судлал
- Хүрээлэн буй орчин судлал
- Уур амьсгал судлал
- Экологи, байгаль хамгаалал
- Мэдээлэлийн технологи
- Инженерчлэл
- Боловсрол судлал
- Хөдөө аж ахуй
- Логистик, үйлдлийн шинжилгээ
- Аж үйлдвэрийн математик

***Хуралдаанд оролцогч нь дараах хэлбэрээр оролцож болно.***

- Илтгэл хэлэлцүүлж хэвлүүлэх
- Постер илтгэл хэлэлцүүлж хэвлүүлэх
- Зөвхөн хурлын эмхэтгэлд хэвлүүлэх

**Хугацааны тов:**

- Мэдүүлэг, эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах **2017-11-05**
- Хурлын программ хэвлэх **2017-11-12**
- Хурал болох **2017-11-25-ны Бямба гараг**

Бүртгэлийн хураамж 1 оролцогч 60 000₮.

Хуралд оролцогчийн мэдүүлгийг <http://seas.num.edu.mn/dep/am/files> хаягаас татаж аваад, дараах талбаруудыг бүрэн бөглөөд зохион байгуулагчид [batbileg@seas.num.edu.mn](mailto:batbileg@seas.num.edu.mn) хаягаар илгээнэ үү.

1. Илтгэл/өгүүллийн нэр
2. Зохиогчийн овог нэр, цол зэрэг, албан тушаал, байгууллага
3. Холбоо барих утас и-мэйл хаяг
4. Оролцох хэлбэр зэргийг тодорхой заана.

Илтгэлийг Эрдэм шинжилгээний өгүүлэл бичлэгийн стандартыг <http://seas.num.edu.mn/dep/am/files> линкээр татаж авна уу.

Хурлын илтгэлүүдээр ISSN индекс бүхий сэтгүүлийн тусгай дугаар гаргана.

Мэдээлэл, лавлагаа авах, холбоо барих утас: 8569-4213, 9918-2806,  
и-мэйл хаяг : [ganbold@seas.num.edu.mn](mailto:ganbold@seas.num.edu.mn), [batbileg@seas.num.edu.mn](mailto:batbileg@seas.num.edu.mn)